



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/24

Хэрлэнбаян-Улаан тосгон

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 25 дугаар зүйлийн 25.1, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4, 3.4.3, 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус тосгонд 2025 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх гудамж талбайд цамхаг гэрэлтүүлэг, камер суурилуулах ажлын гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: А.Нарантуяа – Санхүүгийн албаны дарга

Гишүүд: Б.Энхсаруул – Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Н.Ганцэцэг - Нярав


Т.Хаш-Эрдэнэ - Галч

Ш.Насанбуян – Галч

2. Гудамж талбайд цамхаг гэрэлтүүлэг, камер суурилуулах ажлын гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн ажлын албаны дарга (С.Отгонбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАГЧ



Б.ЭНХЦЭЦЭГ